

Монгол Улс
НЭЗХДШ болон ТС-ийг боловсруулах хүрээнд хөгжлийн түнш байгууллагуудтай
хийсэн зөвлөлдөх уулзалт
2017 оны 9-р сарын 1

Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл ibaatarkhuu@worldbank.org у-мэйл хаягаар Б. Индратай холбогдоно уу.

Дэлхийн Банк Групп (ДБГ) нь Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодлоо солилцох зорилгоор 2017 оны 9-р сарын 1 болон 22-ны өдрүүдэд хөгжлийн түнш 16 байгууллагуудтай уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

- 1) Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
- 2) Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
- 3) Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Ангилал	Оролцогчдоос ирүүлсэн санал
<p>Улс орны хөгжлийн дүн шинжилгээ (ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга зам, боломж, сорилт, бэрхшээл)</p>	<p><u>Боломж</u></p> <ul style="list-style-type: none"> • ОУВС-ийн хөтөлбөр бол тэлэлт, агшилтын мөгчлөгийг хэрхэн эвдэхийг сурах боломж бололцоо юм. Хөтөлбөрт хамрагдсанаар мөчлөгөөс гарах институцийн тогтолцоог бүрдүүлэхээс гадна түүхийг дахин давтахгүйн тулд эдийн засийн өсөлтийн талаар урт болон богино хугацааны арга барилыг сурна. • Монгол Улсын хөгжлийн томоохон боломжууд нь мөн сорилт болдог. Жишээ нь уул уурхайн баялаг ихтэй, хүний хөгжлийн зарим үзүүлэлтээр өндөр байдаг хэдий ч энэ хөгжлийг цааш хадгалахын тулд байгалийн баялгийг зөв удирдах хэрэгтэй. Хөдөө аж ахуй, мал аж ахуй нь ажлын байр бий болгож, амьжиргааг тэтгэдэг ч ДНБ-ий бага хувийг эзэлдэг. • Монгол Улс нь эхийн эндэгдлийг бууруулах Мянганы хөгжлийн сорилтдоо хүрсэн цөөн орнуудын нэг. Мөн боловсрол, эрүүл мэндийн бусад олон үзүүлэлт дээр дэвшил гарсан. • Монгол Улс нь харьцангуй тогтвортой ардчилалтай улс. Хууль эрх зүйн орчин харьцангуй сайн, институцуудын үйл ажиллагаа ерөнхийдөө болж байгаа. Хүний эрхийн тал дээр мөн ахиц дэвшилтэй. <p><u>Сорилтууд:</u></p> <p>Макроэдийн засгийн нөхцөл байдал:</p> <ul style="list-style-type: none"> ○ Эдийн засгийн бүтэц уул уурхайгаас хэт их хараат байна. ЖДҮ зэрэг хувийн хэвшлийн олон арга хэрэгслүүдийг туршиж байгаа боловч эдийн засгийн уул уурхайгаас хараат байдал хэвээр байна.

- Түүхий эдийн үнэ хэтэрхий их хэлбэлзэлтэй байдаг ба Засгийн газрын хяналтаас гадуур байдаг.
- Мөнгөний хомсдол болон өндөр үнээс болж зээлийн хэт их дэврэхэд хүргэсэн. Банкуудын хяналт хяналт сул байдаг тул банкны системийн хараа хяналт сайн болж, макроэдийн засгийн хэрсүү, зөв бодлого барьвал тэлэлт, агшилтын мөчлөгийг давах боломжтой.
- Хятадын эдийн засгийн өсөлт хөшүүрэг болон эдийн засаг өссөний хэрээр зарлага нэмэгдэж, байгалийн баялаг ихтэй орнуудад тулгардаг асуудлууд тулгарсан. Улс оронд хуримтлалыг бий болгох хэрэгтэй. Зарлагыг хяналтанд оруулахын тулд баялгийн санг байгуулж, ашиглах хэрэгтэй. Ойрын хугацаанд өрийн эргэн төлөлт хүлээгдэж байгаа бөгөөд эдгээрийг давсны дараа баялгийн санг ашиглаж эхэлж болно. Төсвийн хороо нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хянах хэрэгтэй.
- Төсвийн хязгаарлалтууд байгаа учир эдийн засаг сэргэх, эдийн засгийн төрөлжүүлэх зэргийг нийгмийн бусад салбаруудтай уялдуулах хэрэгтэй. Төсвийг танахдаа бүх салбарыг хамрахаас зайлсхийх хэрэгтэй, жишээ нь эмнэлэг дээрх эмийн худалдан авалт төсвийн таналтад өртснөөр хүмүүсийн эрүүл мэндэд шууд сөрөг нөлөө үзүүлж байна. 2017 онд эхийн эндэгдэл хоёр дахин нэмэгдсэн. Энэ бүхнээс нэг салбараас хараат байх нь гадны нөлөөнд ямар эмзэг, эрсдэлтэй байгааг харуулж байна.
- Засгийн газрын өрийг хяналтанд байгаа боловч энэ нь хөрөнгө оруулалтыг хязгаарлаж байна.

Эдийн засгийг төрөлжүүлэх:

- Эрчим хүч болон хөдөө аж ахуй зэрэг олон салбарт бага хэмжээний ажлууд хийгдсэн. Гэсэн хэдий ч одоогийн хууль, институцийн бүтцэд хэн ч хөрөнгө оруулах хүсэлгүй байна. Итгэл, эерэг ойлголтыг эргэн бий болгоход 6-8 жил шаардлагатай.
- Одоогийн болон өнгөрсөн арга барил: олон улсад өрсөлдөх чадвар бүхий нэг аж үйлдвэрийг бүрэн гүйцэд хөгжүүлэхэд өнгөрсөнд төвлөрөөгүй.
- Монгол Улс төрөлжилтийг ямар замаар хийх вэ? Олон улс орнууд хүний хөдөлмөр ихээр шаардагддаг аж үйлвэрлэлийг хөгжүүлэхэд анхаардаг боловч Монголд энэ нь тохиромжгүй. Монголын хувьд эдийн засгийг ямар замаар төрөлжүүлэх хэрэгтэй гэдэг дээр ул суурьтай судалгаа шинжилгээ хийгдэх шаардлагатай.
- Төгрөгийн ханш өрсөлдөхүйц байх нь хөдөө аж ахуй зэрэг салбарт төрөлжилтийг авчрах боломжтой.
- Байгаа чадавх, институцийн бүтэцдээ тохироогүй амьдралаас хол хөтөлбөрүүд эдийн засгийг төрөлжүүлэх хүчин чармайлтыг цааш татаж байна.
- Том хэмжээний төслүүдийг техник, эдийн засгийн үндэслэлээс хэрэгжилт рүү цааш явуулах нь Засгийн газрын томоохон сорилт бэрхшээл байж ирсэн.

Улс төрийн тогтворгүй байдал:

- Улс төр бол улс оронд өрнөж буй үйл явдлын нэлээд төвөгтэй хэсэг. Улс төрийн буруу шийдвэр нь өндөр эрсдэл дагуулдаг.
- ОУВС-ийн хөтөлбөрт 4 жил болгон хамрагдаж, Ерөнхий Сайд 1.5 жилд дахин томилогддог нь энэ хоёр харилцан холбоотой гэдгийг харуулж байна.

Засаглал болон ил тод байдал:

- Улс оронд тулгамдаж буй хамгийн том сорилт бэрхшээл бол засаглалын асуудлууд. Макроэдийн засгийн хүрээ сайжирсан ч, засаглал муу бол бодлогын хэрэгжилт хангагдахгүй. Соёл, түүхийнхээ хувьд авч үзсэн ч засаглал бол мөн өөрчлөхөд хамгийн хэцүү зүйл байдаг. Засаглалыг бэхжүүлэх хүлээлт бодит байдалд нийцсэн байх хэрэгтэй.
- Авлигал бол одоогийн асуудлуудын уг үндэс болж байна. Жишээ нь нууц зарлага ДНБ-ий 3 хувьтай тэнцэх хэмжээтэй байна. Төсвийн зарлага, төр-хувийн хэвшлийн түншлэлийн гэрээн доор халхлагдсан ажиллагаа макро эдийн засгийн асуудлуудыг үүсгэж байна.
- Лицензүүдийг тодорхой хэмжээнд барьж байгаад ашиг хийдэг хүмүүс лицензүүдийг эзэмшиж байна. Лицензийн худалдаа ил тод бус байдгаас асуудлуудыг дагуулдаг. Лицензүүдийг хэрхэн журамлах вэ гэдгийг нухацтай авч үзэх ёстой.

Институцийн чадавх болон төрийн алба:

- Институцийн чадавх сул байна. Монголчууд маш их хүсэл эрмэлзэлтэй боловч бодит байдал дээр биеллээ олоход хэцүү төлөвлөгөө босгодог. Эдгээр хэт холын баримт бичгүүдийг одоогийн нөхцөл байдал, чадавханд тулгуурлан хэрэгжиж болохуйц болгон өөрчлөх хэрэгтэй.
- Төлөвлөгөө, хийх ажлын жагсаалтыг эрэмбэлэх чадвар сул. Зарим чиглэлд богино хугацаанд амжилт гаргаж, үр дүнд хүрэх зүйлсээ тодорхойлох хэрэгтэй.
- Төрийн албын шинэтгэл маш чухал боловч хавьгүй илүү урт хугацаанд хэрэгжүүлэх ажил юм.
- Төрийн алба маш тогтворгүй бөгөөд төрийн албан хаагчдын чадавхийг бэхжүүлэхэд маш их зарлага гаргадаг хэдий ч халаа сэлгээнээс болж дахиад бүгдийг шинээр эхлэх хэрэгтэй болдог.
- Улс орны хүн ам бага гэдгийг харгалзан илүү оюуны хөдөлмөрт суурилан эдийн засгийг хөгжүүлэх хэрэгтэй. Энэ нь боловсролын салбарт илүү их хөрөнгө оруулах шаардлагатайг харуулж байна.
- Ажлын байрыг хэрхэн нэмэгдүүлэх вэ гэдгийг шийдвэрлэх ёстой.

Байгаль орчин:

- Бохирдол хамгийн хортой түвшинд хүрсэн.
- Монгол улс уур амьсгалын өөрчлөлтөд маш их өртсөн ба хүмүүс хөдөөгөөс гарахад хүрч Улаанбаатар луу чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлж байна. Ингэснээр төрийн үйлчилгээний хүртээмж, чанарт муу нөлөө үзүүлэн, Улаанбаатарын бохирдлыг асуудлыг лавшруулж байна. Монгол улсад ядуурал, байгаль орчны асуудлууд нягт холбоотой.
- Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой ихэнх төслүүд нь хандивлагч, донор байгууллагуудын санхүүжилттэй байна. Эдгээр төслүүд дууссаны дараа асуудал гүнзгийрэх эрсдэлтэй тул тэдгээрийг одоо шийдэх хэрэгтэй.

Эрүүл мэнд:

- Хөгжлийн түншүүдийн санхүүжилттэй эрүүл мэндийн салбарын төслүүд цөөрч байгаа тул уг салбарт дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хэрэгтэй. Эрүүл мэндийн үйлчилгээ хүртэгчдийн зүгээс өөрсдөө гаргаж

	<p>байгаа зардал өндөр байна. Улсын төсөв, даатгалын сангаас эрүүл мэндийн салбарт хуваарьлагдаж байгаа боловч хувь хүмүүсийн төлж буй төлбөр маш өндөр байна (ихэнх зардал нь эм худалдан авахад гардаг). Эмний үнэ өндөр бөгөөд үүнийг зохицуулдаггүй.</p> <ul style="list-style-type: none"> ○ Сүрьеэ зэрэг томоохон халдварт өвчнүүдийн улмаас олон хүмүүс ядууралд автаж байна. Эмийн олдоц муу. ○ Халдварт бус өвчинд чиглэсэн хөрөнгө оруулалт маш удаан хугацаанд үр ашгаа өгдөг тул засгийн газрын зүгээс богино хугацаанд үр дүнгээ өгөх хөрөнгө оруулалтыг хийхийг илүүд үздэг. Халдварт бус өвчлөлийг бууруулахын тулд засгийн газрыг урт хугацааны хөрөнгө оруулалт хийхэд нь чиглүүлэх хэрэгтэй. ○ Нөгөө талдаа Монгол улс эрүүл мэндийн салбар дахь дотоодын нөөцийг ашиглаад явах боломжтой, харин нөөцийг илүү үр ашигтай ашиглан зарцуулах хэрэгтэй. <p>Бусад:</p> <ul style="list-style-type: none"> ○ Ардчилсан хувьсгалын дараа төрсөн залуусын боловсрол, хөгжилд анхаарах хэрэгтэй. Бүрэн дунд болон ахлах сургуулиудын боловсролын чанар муудсан. Залуу үеийхний дунд амиа хорлолт, тамхидалт, хар тамхи хэрэглэх явдал нэмэгдэж байгаа нь санаа зовниулсан асуудал болж байна. ○ Нийгмийн халамжийн асуудлыг Монголд илүү цогцоор нь харах хэрэгтэй, учир нь одоогийн байдлаар нийгмийн халамж гэдэг нь хүүхдийн мөнгө тараах гэж явцуу ойлгодог. Хүүхдийн мөнгийг тараах байгаа ч чанартай боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хүмүүс хүртэж чадахгүй байгаа нь тэднийг эмзэг байдал руу түлхэж байна.
<p>ДБГ-ын хамтын ажиллагаа, түншлэлийн стратегийн талаар өгсөн санал</p>	<p>Цаашид дэмжих чиглэл:</p> <ul style="list-style-type: none"> • Монгол улс урт хугацаанд тогтвортой, өргөн хүрээний өсөлт, эдийн засгийн төрөлжилтийг хэрхэн бий болгох вэ гэдэгт Түншлэлийн стратегийг төвлөрүүлэх. ДБГ-ийн харьцангуй давуу тал, туршлага дээр үндэслэн Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх, байгалийн баялгаа ашиглан хүний хөгжилд хөрөнгө оруулах, ажлын байрыг бий болгон, үр ашгийг нь олноороо хүртэх өсөлт, амьжиргааг дээшлүүлэх чиглэлд ажиллах нь зүйтэй. • Засаглал: төрийн эрх баригчдын дундах үүрэг роль зэрэг Үндсэн хуулийн шинэчлэлийн томоохон асуудлууд дээр дэмжлэг тусалцаа үзүүлэх. Тогтвортой, мэргэшсэн төрийн албыг байгуулах чиглэлээр төрийн албаны шинэтгэл хийх. Олон улсын тэргүүн туршлагад үндэслэн хууль журам боловсруулах зэрэг институцийн чадавх болон засаглалын асуудлын голд нь байдаг мэргэжлийн зөвлөмж зөвлөгөө олгох хэрэгтэй. • Монгол дахь авлигын асуудлыг шийдвэрлэхэд төвлөрч болно. • Бүх нийтийн эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн санаачилгад ДБГ мөн оролцдог тул эрүүл мэндийн үйлчилгээнд иргэдийн зүгээс төлж буй төлбөрийг бууруулах тал дээр хөгжлийн бусад түнш байгууллагуудтай хамтран ажиллах боломжтой. • Хөрөнгө оруулалтын хэрэгцээг илүү сайн эрэмбэлдэг болох, бүтцээ сайжруулахад дэмжлэг тусалцаа үзүүлэх. • Эрүүл мэнд, боловсролын салбарт бусад донор байгууллагуудын хөрөнгө оруулалт хязгаарлагдмал байдаг асуудлууд дээр дэмжлэг үзүүлэх. Тухайн салбарын арай өргөн хүрээний асуудлууд дээр төвлөрөх. • Уул уурхайн засаглал, лицензүүдийн асуудал зэргийг шийдвэрлэх.

	<p>Арга зам, хэрэгжилт:</p> <ul style="list-style-type: none"> • Дэлхийн Банк арай том хэмжээний төслүүдийг санхүүжүүлэх хэрэгтэй. ДБГ-ийн нөөц бололцоо болон Монголын хөгжлийн боломжийг ашиглан сэргээгдэх эрчим хүч зэрэг томоохон хэмжээний төслүүдэд санхүүжилт хийх. • Салбарын арай өргөн хүрээний асуудлуудад чиглэсэн төслүүдийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлэх. Дэлхийн Банк арай өргөн хүрээний асуудлууд дээр төвлөрөн, бусад байгууллагууд арай жижиг хэмжээний, тодорхой асуудлууд дээр төвлөрөн ажиллах боломжтой. • Байгаа нөөцийг бүх салбарт бага хэмжээгээр хуваарилахгүйгээр дэмжлэг үзүүлэх гол чиглэлүүдээ тодорхойлох хэрэгтэй. Засгийн газар болон иргэдэд жижиг хэмжээний загвар төслүүдийг хэрэгжүүлэн, хэрхэн яаж хийх боломжтой гэдгийг харуулах хэрэгтэй. Жишээ нь гэр хорооллын нэгэн жижиг хороо, хэсгийг цогцоор нь хөгжүүлж, бусад хүмүүст үлгэрчлэн, загвар болгох хэрэгтэй. • Төсвийн дэмжлэг үзүүлэхдээ нийгмийн гол салбаруудын хөрөнгө оруулалтыг танахгүй байх хэрэгтэй гэж засгийн газарт зөвлөмж өгөх нь зүйтэй. Төсвийг Тогтвортой хөгжлийн зорилттой уялдуулж боловсруулах, жишээ нь нийгэм, байгаль орчинд чиглэсэн төсвийг үргэлжлүүлэн олгох. Ядууст дэмжлэг болох төсвийг хөхиүлэн дэмжих. • Том хэмжээний шинэтгэлийг явуулах, дэмжих ДБГ-ын харьцангуй давуу талыг ашиглах. ДБГ нь мөн олон улсын санхүүгийн байгууллагуудын дунд уялдаа холбоог хангах, зохицуулах чиглэлээр ажиллаж, хамтын ажиллагааны хүрээг бий болгож болно. • Мэдлэгийн үнэ цэнийг дутуу үнэлж болохгүй. Төрийн секторын засаглалыг суурийг нь бэлдэх, бодлогын зөвлөмжүүдээр дамжуулан сайжруулах боломжтой. • Ойрын хугацаанд тулгарах сорилт, бэрхшээлүүдийг бодолцон тооцоолж, биелэх боломжтой бодит зорилтуудыг тавихад цаг зарцуулах хэрэгтэй. • Тэргүүн туршлага, сайн туршлага зэрэгт төвлөрөх. • Улс төрийн нөхцөл байдлыг харгалзан цаг хугацааны хувьд уян хатан байх. • Зээлийн төслүүдийг боловсруулах, хэрэгжүүлэхэд авсан хуучин сургамжуудаас суралцах. • Монголд нөхцөл байдал хурдан өөрчлөгдөж болохыг харгалзан уян хатан байх.
<p>Бусад</p>	<ul style="list-style-type: none"> • Хөгжлийн түншүүд нэг нэгнийхээ үйл ажиллагааг нөхөн, бусдынхаа ажиллаагүй салбар, үйл ажиллагаанд төвлөрөх хэрэгтэй. • НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд болон олон улсын санхүүгийн байгууллагууд өөрсдийн тэмдэглэл, дүн шинжилгээ, тэр дундаа төсвийн асуудлууд дээр илүү их харилцан солилцож байх хэрэгтэй. • Хөгжлийн уялдаа холбоотой дэмжлэг үзүүлэхийн тулд хөгжлийн түнш, донор байгууллагуудын уялдаа холбоо, тогтмол мэдээлэл солилцох явц маш чухал.

Уулзалтын үеэр оролцогчдоос авсан товч судалгааны хариу:

1. Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг бууруулж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

Боломжит хариулт	Оролцогчдын хариулт
Төрийн удирдлага/шинэтгэл	100.00% 8
Байгалийн нөөцийн удирдлага	75.00% 6
Авлигатай тэмцэх	50.00% 4
Гадаадын хөрөнгө оруулалт	50.00% 4
Боловсрол	37.50% 3
Зам, тээвэр	25.00% 2
Эдийн засгийн өсөлт	25.00% 2
Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	25.00% 2
Эрчим хүч	25.00% 2
Хотын хөгжил	25.00% 2
Хөдөөгийн хөгжил	12.50% 1
Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	12.50% 1
Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	12.50% 1
Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах	12.50% 1
Санхүүгийн зах зээл	0.00% 0
Бусад	0.00% 0
Хувийн хэвшлийг хөгжүүлэх	0.00% 0
Худалдаа, экспорт	0.00% 0
Гамшгийн эрсдэлийн удирдлага	0.00% 0
Нийгмийн хамгаалал	0.00% 0
Эрүүл мэнд	0.00%

Боломжит хариулт	Оролцогчдын хариулт
	0
Ус, ариун цэврийн байгууламж	0.00% 0
Эрх тэгш боломжоор хангах	0.00% 0
Хүнсний аюулгүй байдал	0.00% 0
2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж Та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)	84.62%
Хүний хөгжлийг дэмжих	
Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	53.85%
Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	30.77%
Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих	30.77%
Бүгд чухал	30.77%
Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	7.69%